Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,209,888.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 64,197.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж суурь үзүүлэлтээр тооцсон өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тайлант оны зардал 59,623.7 мянган төгрөг буюу 18.2 хувиар өссөнөөр гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,269,511.9 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 65,390.2 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө дүн өмнөх оноос 188,949.3 мянган төгрөгөөр буюу 2.4 хувиар буурч, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж төлсөн тооцоо, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн дансууд байна.

| Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| **Б** | **1** | **2** | **3=2-1** |
| Мөнгөн хөрөнгө | 1,061.1 | - | (1,061.1) |
| Авлага | 179,459.5 | 62,618.8 | (116,840.7) |
| Урьдчилж төлсөн тооцоо/ зардал | 225,891.5 | 306,785.3 | 80,893.8 |
| Бараа материал | 65,852.1 | 77,580.7 | 11,728.5 |
| Үндсэн хөрөнгө | 7,537,089.2 | 7,373,419.4 | (163,669.7) |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | **8,009,353.5** | **7,820,593.0** | (188,760.5) |

| | | | |
|---|---|---|---|
| Өр төлбөр | **22,756.8** | **5,127.2** | (17,629.6) |
| **Засгийн газрын хувь оролцоо** | 7,986,596.7 | 7,815,465,8 | (171,3130.9) |
| **Нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **8,009,353.5** | **7,820,593.0** | (188,760.5) |

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараахь өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны өмнөх оны үлдэгдлээс зарцуулж 1,061.1 мянган төгрөгөөр буурсан;
- Авлага дансны эхний үлдэгдлээс байгаль орчны яамтай хамтарсан төслийн тоног төхөөрөмжийн урьдчилгаа төлбөр 73,000.0 мянга, гадаадтай хамтарсан төслийн 1,106,459.5 мянган төгрөгийн авлага харилцах дансанд орж ирсэн, тайлант онд татаас санхүүжлтийн 28,620.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлэн авлага үүсгэсэн, нийгмийн даатгалын шимтгэлийн 1,829.5 мянга, бусад зардлын тооцооны авлага 32,168.7 мянган төгрөгийн авлага нь хил хаагдсанаас бараа материал ондоо багтаж ирээгүй 6 байгууллагатай холбоотой нийт 116,840.7 мянган төгрөгөөр буурсан;
- Урьдчилж төлсөн тооцоо дансны эхний үлдэгдлээс ковид 19 цар тахалтай холбоотойгоор хятад улсын хил хаагдаж тоног төхөөрөмж ,сэлбэг хэрэгсэл орж ирээгүйгээс 80,893.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн;
- Бараа материал дансны эхний үлдэгдлээс шинжлэх ухааны чиглэлээр судалгаа шинжилгээ хийхэд шаардлагатай урвалж бодис авч 11,728.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн;
- Үндсэн хөрөнгө данс тайлант оны элэгдлийн зардлаас голлон шалтгаалж 163,669.7 мянган төгрөгөөр буурсан;
- Өр төлбөр данс өмнөх оны урьдчилж орсон орлого 4,868.5 мянган төгрөг, нийслэлийн газрын албанд 258.7 мянган төгрөгийн өглөгөөр нэмэгдсэн;

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хими, химийн технологийн хүрээлэн нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,863,495.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,863,495.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 212,951.7 мянган төгрөгөөр бууруулж, 2,650,543.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийг ажилчид судалгааны ажлын арга барил эзэмшсэн байдал, ур чадварын түвшингийн зэрэг дэв ахиулах зорилгоор ажилтныг 4 жил тутамд аттестатчилалд хамруулахаар цалингийн нэмэгдэл олгох санал оруулсан боловч нэмээгүйгээс цалин, нийгмийн даатгалын зардал 102,158.1 мянган, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 15,943.7 мянган, урсгал засварын зардлыг 39,242.0 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 46,972.4 мянга, нийт 212,951.7 мянган төгрөгийг бууруулж баталжээ.

Тус хүрээлэн нь олон төрлийн химийн бодис ашиглаж, судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэдгээс ажиллагсдын дунд хорт хавдар өвчлөл их байдаг учраас жилд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах шаардлагатай тул ажилчдад бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын санхүүжилтийг нэмж тодотгох хүсэлт тавьж шийдвэрлүүлснээс шалтгаалж батлагдсан төсвөөс 9,847.0 мянган төгрөгөөр нэмж төсвийг тодотгосон байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,660,390.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 2,660,390.9 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч, 2,576,788.1 мянган төгрөгийг зарцуулж, 96.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,576,788.1 мянган төгрөг буюу 96.9 хувьтай байгаа нь цалин, нэмэгдэл, НДШ-ийн зардлыг 59,788.1 мянган, байр ашиглалттай холбоотой зардлыг 3,831.2 мянган, хангамж бараа материалын зардлыг 417.6 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 19,565.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

*Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл* /мянган төгрөг/

| Д/Д | Хөтөлбөр, арга хэмжээний | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| | Код | Нэр | | | | |
| 1 | 71805 | Шинжлэх ухаан, технологи хөтөлбөр | 2,660,390.9 | 2,576,788.1 | 83,602.8 | 96.9 |
| 1.1 | 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 2,576,265.9 | 2,494,085.2 | 82,180.7 | 96.8 |
| 1.2 | 80219 | Харуул, хамгаалалтын зардал | 47,775.0 | 47,232.9 | 542.1 | 99.0 |
| 1.3 | 80215 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 30,000.0 | 29,920.0 | 80.0 | 99.7 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд гадаадын төсөл хөтөлбөрөөс орж ирсэн санхүүжилт 197,826.5 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 208,247.5 мянга, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон шинжилгээний орлого 214,191.2 мянга, мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,061.1 мянга нийт 621,326.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин, нийгмийн даатгалын зардалд 73,510.3 мянга, хангамж бараа материалын зардалд 6,903.1 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 83,400.8 мянга, албан томилолтын зардалд 3,000.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 411,994.9 мянга, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд 5,000.0 мянга, нийт 591,951.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 29,374.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлснээс 28,620.5 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар тусгасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, 3 арга хэмжээний хэрэгжилт 99.7 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 96.9 хувийн биелэлттэй, 3.2 хувь буюу 83,602.7 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Хими, химийн технологийн хүрээлэн нь тайлант онд дээд газрын төсөв захирагчийн шийдвэргүй нэмэлт санхүүжилтээр 36,653.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэснийг онцолсон хэсэгт тусгах нь зүйтэй гэж үзлээ.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайланд 28,620.5 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулаагүй үлдэгдлийг төвлөрүүлэх шилжүүлгийг буцаан авахаар авлагаар бүртгэсэн байна.

### 3.9 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудит, нийцлийн аудитыг хослуулан хийх явцад нийцлийн асуудлаар тусад нь дүгнэлт гаргах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хими, химийн технологийн хүрээлэн нь нийт 211 мэдээллийн 5,313,934.1 мянган төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 550,291.3 мянган төгрөгийн 91 мэдээллийн холбогдох шийдвэрийг хугацаа хоцроож байршуулсан зөрчилтэй байна.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална” 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” 4.1.2 “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулаагүй, шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан. Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Монгол Улсын ерөнхий аудиторын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/111 дүгээр тушаалаар баталсан Ерөнхий чиглэл, аргачилсан зөвлөмжийн дагуу гаргасан судалгааг шалгагдагч байгууллагаар гаргуулан хянаж аудитдаа ашигласан болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 447,071.3 мянган төгрөгийн алдаа 5 зөрчил илэрүүлж ззөвлөмж өгч жилийн эцсийн аудитаар дахин хянахад 424,176.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж биелээгүй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 75,222.8 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай, 2 албан шаардлага өгсөнөөс шилэн дансны мэдээлэл хугацаандаа оруулаагүй албан шаардлага хэрэгжээгүй байна.

*Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 2 | 75,222.8 | 2 | 75,222.8 | - | - | 100 |
| Албан шаардлага | 2 | 0 | 1 | 0 | 1 | - | 50 |
| Нийт дүн | 4 | 75,222.8 | 3 | 75,222.8 | - | - | 75 |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар тус хүрээлэн нь өөрийн лабораторт шинжилгээ хийх боломжгүй шинжилгээг гадны лабораториор хийлгэдэг шинжилгээний төлбөр, үндсэн үйл ажиллагааны лабораторийн шинжилгээний орлогоос олгосон урамшуулал, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх дотоод хяналт шалгалтын үр дүнг анхаарах гол асуудлаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 41,925.7 мянган төгрөгийн 12 алдаа зөрчил илэрснээс, 25,517.5 мянган төгрөгийн 6 алдааг залруулж, 2,778.5 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 6,448.1 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 7,181.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 16,408.3 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлаас 48,981.9 мянган төгрөгөөр бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Үр дүнгийн тайланд гэрэл цахилгаан, түлш халаалт, тээвэр шатахууны зардлыг 5,334.2 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн;
- Ажилчдад үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан 1,666.1 мянган төгрөгийн цалин олгосон;
- Санхүүгийн тайланд нийгмийн даатгалын өглөгийг 15,894.3 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
- Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг санхүүгийн тайланд 561.8 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн;
- ТӨБЗГ-ын шийдвэрээр үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй Beitang WT-220A маркийн тракторыг ШУА-ын харьяа Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнд балансаас балансад шилжүүлсэн хөрөнгийн буруу бичилт хийсэн;
- Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,061.1 мянган төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэмэлт орлогоор бичилт хийсэн;

### 4.2 Төлбөрийн акт

1. Автомашины шатахуун зарцуулалтыг давтан тооцоолоход жолоочийн тооцооны замын хуудас бичсэн боловч автомашины 100 км-т зарцуулах норм лимитээр тооцож олгоогүйгээс 197.9 л буюу 385.5 мянган төгрөгийн шатахуун илүү зарцуулсан байна.

Энэ нь Зам тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 7дугаар хавсралт "автомашины шатахуун зарцуулалтын нормыг тооцох заавар"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

1. Албан томилолтоор ажилласан хугацаанд ажиллагчдад 1,685.0 мянган төгрөгийн томилолтыг илүү бодож олгосон, томилолтоор ажилласан хугацаанд унаа, хоолны нэмэгдэл 708.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

### 4.3 Албан шаардлага

Нэмэлт санхүүжилтийн данснаас шатахууны зардал 4,064,100.00 төгрөгийг шилжүүлсэн боловч замын хуудасгүй, шатахууны тооцоог бодоогүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу албан томилолтын 2,384.0 мянган төгрөг нийт 6,448,100.00 мянган төгрөгийг санхүүгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг давтан гаргахгүй байх. Албан шаардлага өгөх.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал***

*Илрүүлэлт:*

ТӨБЗГ-ын үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах тогтоолын дүнгээс 6,536.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас илүү хассан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1,2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

ТӨБЗГ-ын үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах тогтоолын дүнгээс хөрөнгийн нэг бүрийн үнэ зөрүүтэй хассан хөрөнгийг залруулах.

### *2. Зардлын данстай холбоотой асуудал*

*Илрүүлэлт:*

Нийгмийн даатгалын тайланд цалинг 645.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүлйин 17.1 “ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж тогтоосон хугацаанд нь төлөх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Нийгмийн даатгалын тайланд илүү тайлагнасан цалинг суутган тайлагнах, зөрчлийг хойшид давтан гаргахгүй байх.

### *3. Дотоод хяналтай холбоотой асуудал*

*Илрүүлэлт:*

Харилцах дансны гүйлгээг баримттай тулган баталгаажуулж шалгахад баримт эмх цэгцгүй нэмэлт санхүүжилтийн тайлант оны баримтуудыг үдэж архивын нэгж бүрдүүлээгүй нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1 “албан хэрэг хөтлөлтийн явцад үүссэн хавтаст баримтыг зохион байгууллалтын нэгж, ажилтнаас бүрэн бүрдэлтэй хүлээн авах”, 24 дүгээр зүйлийн 24.1 “байгууллагын архив тухайн байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж, архивын баримтыг анхан шатанд бүрдүүлж, энэ хуульд заасан хугацаагаар түр хадгална” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Тайлант оны анхан шатны баримтуудыг архивын нэгж бүрдүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Байгууллагын нэр | Аудитын код | Алдаа зөрчлийн утга | Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс Залруулга | | Акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | дүн | тоо | дүн | Тоо | дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | Хими, химийн технологийн хүрээлэн | АХГ-2022/53/НА-СТА-ТШЗ | Үр дүнгийн тайланд гэрэл цахилгаан, түлш халаалт,тээвэр шатахууны зардлыг 5,334.2 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн. | СҮДТ-ийн зардлыг залруулсан | 1 | 5,334.2 | 1 | 5,334.2 | | | | | | | | |
| 2 | Хими, химийн технологийн хүрээлэн | АХГ-2022/53/НА-СТА-ТШЗ | Санхүүгийн тайланд тусгасан нийгмийн даатгалын өглөг 15,894.3 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн | СТ-ийн өглөгийн үлдэгдлийг залруулсан | 1 | 15,894.3 | 1 | 15,894.3 | | | | | | | | |
| 3 | Хими, химийн технологийн хүрээлэн | АХГ-2022/53/НА-СТА-ТШЗ | Ажилчдад үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан 1,666.1 мянган төгрөгийн цалин олгосон | Завсарын аудитаар залруулсан | 1 | 1,666.1 | 1 | 1,666.1 | | | | | | | | |
| 4 | Хими, химийн технологийн хүрээлэн | АХГ-2022/53/НА-СТА-ТШЗ | Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,061.1 мянган төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэмэлт орлогоор бичилт хийсэн | Аудитын явцад залруулсан | 1 | 1,061,1 | 1 | 1,061.1 | | | | | | | | |
| 5 | Хими, химийн технологийн хүрээлэн | АХГ-2022/53/НА-СТА-ТШЗ | Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 561.8 мянган төгрөгөөр илүү тооцож тайланд тусгасан | СБТ-д элэгдлийг залруулсан | 1 | 561.8 | 1 | 561.8 | | | | | | | | |
| 6 | Хими, химийн технологийн хүрээлэн | АХГ-2022/53/НА-СТА-ТШЗ | жолоочийн тооцооны замын хуудас бичсэн боловч автомашины 100 км-т зарцуулах норм лимитээр тооцож олгоогүйгээс 197.9 л буюу 385.5 | Норм лимитээр тооцож олгоосон шатахуунд | 1 | 385.5 | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мянган төгрөгийн шатахуун илүү зарцуулсан | Төлбөрийн акт тогтоох | | | | | 1 | 385.5 | | | | | | |
| 7 | Хими, химийн технологийн хүрээлэн | АХГ-2022/53/НА-СТА-ТШЗ | Албан томилолтоор ажилласан хугацаанд ажиллагчдад 1,685.0 мянган төгрөгийн томилолтыг илүү бодож олгосон, унаа,хоолны нэмэгдэл 708,0 мянган төгрөгийг давхардуулан олгосон. | Илүү бодож олгосон томилолт, унаа,хоолны нэмэгдэлд төлбөрийн акт тогтоох | 1 | 2,393.0 | | | 1 | 2,393.0 | | | | | | |
| 8 | Хими, химийн технологийн хүрээлэн | АХГ-2022/53/НА-СТА-ТШЗ | Нэмэлт санхүүжилтийн данснаас шатахууны зардалд 4,064.1 мянган төгрөгийн шилжүүлсэн боловч замын хуудасгүй, шатахууны тооцоог бодоогүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу албан томилолтын 2,384.0 мянган төгрөг нийт 6,448,100.00 мянган төгрөгийг санхүүгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн | Анхан шатны баримтын бүрдэл дутуу зарцуулахгүй ажиллах | 1 | 6,448.1 | | | | | 1 | 6,448.1 | | | | |
| 9 | Хими, химийн технологийн хүрээлэн | АХГ-2022/53/НА-СТА-ТШЗ | Харилцах дансны гүйлгээг баримттай тулган баталгаажуулж шалгахад баримтын бүрдэлүүд хийгдсэн ч эмх цэгцгүй, нэмэлт санхүүжилтийн тайлант оны баримтуудыг архивын нэгж бүрдүүлээгүй | Тайлант оны баримтуудыг архивын нэгж бүрдүүлж ажиллах. | 1 | 0 | | | | | | | | | 1 | 0 |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | Хими, химийн технологийн хүрээлэн | АХГ-2022/53/НА-СТА-ТШЗ | ТӨБЗГ-ын үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах тогтоолын жагсаалтаас 6,536.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас илүү хассан | ТӨБЗГ-ын үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах тогтоолын жагсаалтаас хөрөнгийн нэг бүрийн үнэ зөрүүтэй хассан хөрөнгийг 2022 оны 1-р улиралд багтаан залруулах. | 1 | 6,536.6 | | | | | | | | | 1 | 6,536.6 |
| 11 | Хими, химийн технологийн хүрээлэн | АХГ-2022/53/НА-СТА-ТШЗ | ТӨБЗГ-ын шийдвэрээр балансаас балансад шилжүүлсэн 1,000.0 мянган төгрөгийн хөрөнгийн буруу бичилт хийсэн | Аудитын явцад залруулсан | 1 | 1,000.0 | 1 | 1,000.0 | | | | | | | | |
| 12 | Хими, химийн технологийн хүрээлэн | АХГ-2022/53/НА-СТА-ТШЗ | Нийгмийн даатгалын тайланд цалинг 645.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан | Нийгмийн даатгалын тайланд илүү тайлагнасан цалинг 2022 оны 1-р улиралд суутган тайлагнах | 1 | 645.0 | | | | | | | | | 1 | 645.0 |
| **Дүн** | | | | | 12 | 41,925.7 | 6 | 25,517.5 | 2 | 2,778.5 | 1 | 6,448.1 | | 0 | 3 | 7,181.1 |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | Хими, химийн технологийн хүрээлэн | АХГ-2022/53/НА-СТА-ТШЗ | Шилэн дансанд 15,618.9 мянган төгрөгийн 32 шийдвэр, 534,672.4 мянган төгрөгийн 59 гэрээг хугацаа хоцороож байршуулсан | Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан холбогдох ажилтанд хариуцлага тооцох | 1 | 550,291.3 | | | | | 1 | 550,291.3 | 1 | 550,291.3 | | |
| Дүн | | | | | 1 | 550,291.3 | | | | | 1 | 550,291.3 | 1 | 550,291.3 | | |
| **Нийт дүн** | | | | | 13 | 592,217.0 | 6 | 25,517.5 | 2 | 2,778.5 | 2 | 556,739.4 | 1 | 550,291.3 | 3 | 7,181. |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АКТ**

2022 оны 02 дугаар сарын 25 № 24/А0150058 Улаанбаатар хот

АХГ - 2022/53/НА - СТА - ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Автомашины шатахуун зарцуулалтыг давтан тооцоолоход жолоочийн тооцооны замын хуудас бичсэн боловч автомашины 100 км-т зарцуулах норм лимитээр тооцож олгоогүйгээс 197.9 л буюу 385,500.00 төгрөгийн шатахуун илүү зарцуулсан, албан томилолтоор ажилласан хугацаанд ажиллагчдад 1,685,000.00 төгрөгийн томилолтыг илүү бодож олгосон, томилолтоор ажилласан хугацаанд унаа, хоолны нэмэгдэл 708,000.00 төгрөгийг давхардуулан олгосон.

Энэ нь Зам тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 7 дугаар хавсралтаар баталсан "автомашины шатахуун зарцуулалтын нормыг тооцох заавар"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3 заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хими, химийн технологийн хүрээлэн нь ажилтанд албан томилолтоор ажилласан хугацаанаас томилолт илүү бодож 1,685,000.00 төгрөг, унаа,хоолны нэмэгдлийг давхардуулан 708,000.00 төгрөг, автомашины 100 км-т зарцуулах нормоос илүү 385,500.00 төгрөг нийт 2,778,500.00 /хоёр сая долоон зуун далан найман мянга таван зуун/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкан дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал Л.Жаргалсайхан, ахлах нягтлан бодогч Ч.Гэрэлтуяа нарт хариуцуулав.

**АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.СЭРЖМЯДАГ

ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР Г.ЦЭЦЭГМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264250

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 02 дугаар сарын 25 № 122/А0150058 Улаанбаатар хот
АХГ-2022/53/НА-СТА-ТШЗ

**Сахилгын хариуцлага тооцуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хими, химийн технологийн хүрээлэн нь 5,313,934,100.00 төгрөгийн 211 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 550,291,300.00 төгрөгийн 91 мэдээллийн холбогдох шийдвэрийг хугацаа хоцроож байршуулсан зөрчилтэй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2 заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулаагүй, Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан Хими, химийн технологийн хүрээлэнгийн ахлах нягтлан бодогч Ч.Гэрэлтуяад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал Л.Жаргалсайханд даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Б.СЭРЖМЯДАГ |
| ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР | Г.ЦЭЦЭГМАА |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

0010800398

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 02 дугаар сарын 25 № 123/А0150058 Улаанбаатар хот
АХГ-2022/53/НА-СТА-ТШЗ

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэмэлт санхүүжилтийн данснаас шатахууны зардалд 4,064,100.00 төгрөгийг шилжүүлсэн боловч замын хуудасгүй шатахууны тооцоог бодоогүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу томилолтын 2,384,000.00 төгрөг нийт 6,448,100.00 мянган төгрөгийг санхүүгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал Л.Жаргалсайхан, ахлах нягтлан бодогч Ч.Гэрэлтуяа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР — Б.СЭРЖМЯДАГ
ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР — Г.ЦЭЦЭГМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

0010800395

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ